



# СОЙМБОМ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

# МЭДЭЭ

№112 /112/

2021.08.13

## ҮЙЛ ЯВДАЛ

### МАНАЙ БАГ ТАМИРЧИД ЗОРЬСОН ГАЗРАА ХҮРЛЭЭ



ОХУ-ын Батлан хамгаалах яамнаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Олон улсын цэргийн наадм-2021" цогцолбор тэмцээний хүрээнд явагдах "Аравт-2021" олон улсын морин цэргийн болон "Цэргийн ралли" цэргийн авто машины уралдаанд оролцох Монгол Улсын Зэвсэгт хүчний баг, тамирчид энэ сарын 11-нд зорьсон газраа саадгүй очоод байна.

"Аравт" олон улсын морин цэргийн уралдааныг өөрийн эх оронд зохион байгуулахаар төлөвлөлтийн хурлуудыг хийж, бэлтгэл ажлуудыг сайтар хангасан боловч дэлхий нийтэд болон манай улсад дэгдсэн цар тахлын улмаас энэ удаа ОХУ-ын Тува улсын нийслэл Кызыл хотноо зохион байгуулах шийдвэр гарсан юм.

Энэ удаад "Аравт-2021" олон улсын морин цэргийн болон "Цэргийн ралли" цэргийн авто машины уралдаанд оролцох Монгол Улсын Зэвсэгт хүчний баг, тамирчдыг Монголын талын зохион байгуулах хорооны дарга, ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг, "Танкийн биатлон" олон улсын тэмцээнд оролцох

бүрэлдэхүүнийг ЗХЖШ-ын Материал, техникийн газрын штабын удирдлага, төлөвлөлтийн ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Х.Санчирдорж ахлаж юм.

Одоогоор тэмцээний тов гараагүй байгаа бөгөөд манай алба хаагчид тусгаарлалтад байна.

Өмнөх жилүүдэд Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид энэхүү олон улсын цэргийн наадмын "Танкийн биатлон", "Хээрийн гал тогоо", "Инженерийн томьёолол", "Мэргэн буудагчийн зааг" тэмцээнд үндсэн оролцогчоор, "Цэлмэг тэнгэр", "Артиллерийн галын мастер", "Аюулгүй орчин" тэмцээнд ажиглагчаар оролцож байсан. Мөн 2019 онд манай орон анх удаагаа зохион байгуулагч улсын статустайгаар оролцож "Аравт" олон улсын морин цэргийн уралдааныг өөрийн эх оронд амжилттай зохион байгуулснаар зохион байгуулагчдын зүгээс өндөр үнэлэлт авч байлаа. Тэрхүү уралдаанд Монгол, Орос, Казахстан, Киргиз Улсын Зэвсэгт хүчний баг тамирчид өрсөлдөж, Хятад, Америк, Зимбабве, Вьетнам зэрэг орон ажиглагчаар оролцож байсан юм.

## БЭЛТГЭЛ ҮҮРЭГТНИЙ СУРГАЛТ ЭХЭЛЛЭЭ

### Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Монгол Улсын Дайчилгааны тухай хуулийн 29 дүгээрзүйл, Батланхамгаалахын сайдын Нийслэлийн Засаг даргатай 2021 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн байрлалд Зэвсэгт хүчний 303 дугаар ангитай хамтран зохион байгуулж байгаа бэлтгэл үүрэгтний сургалт өчигдөр эхэллээ.

Уг сургалтад оролцох бие бүрэлдэхүүнийг Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын бие бүрэлдэхүүн дүүргийн Спорт хорооны байранд хүлээн авч халдвар хамгаалалтын дэглэмийг сахин "Ковид-19"-ын түргэвчилсэн оношлуураар шинжилгээнд хамруулж, нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнүүдийг Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн сургалтын төвд хүлээлгэн өгсөн байна.



## СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА

Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд 2021-2022 онд үүрэг гүйцэтгэх цэргийн ажиглагч офицер, штабын ажилтны сонгон шалгаруулалтыг 2021 оны 9 дүгээр сарын 20-ноос 24-ны өдрүүдэд зохион байгуулна.

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй цэргийн алба хаагчид

2021 онд шинээр батлагдсан "Энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах бие бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах журам"-тай танилцаж, НҮБ-ын цэргийн ажиглагч, штабын ажилтанд тавигдах шаардлагыг хангасан байх ба ЗХЖШ-ын АУГ-ын Энхийг дэмжих ажиллагааны хэлтэст доорх материалыг бүрдүүлэн 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ. Үүнд:

1. Харьяа анги, байгууллага, төрлийн цэргийн командлал

болон ЗХЖШ-ын бүтцийн нэгжийн удирдлагын зөвшөөрсөн цохолттой хувийн өргөдөл;

2. Ажил байдлын тодорхойлолт

3. Жолооны үнэмлэхний хуулбар;

4. Цэргийн ажиглагч, штабын офицерын сургалт, дамжаа дүүргэсэн сертификатын хуулбар;

5. Сүүлийн 3 сарын дотор авахуулсан 4х6 хэмжээтэй цээж зураг 2 хувь.

6. Товч судалгаа

7. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт

**Жич:** Шаардлагатай нэмэлт мэдээллийг АУГ-ын ЭДАХ-ийн psod@mil.gov.mn цахим шуудангаар болон /3203, 92115982/-тэй холбогдож тодруулж болно.

ЗХЖШ-ЫН АУГ-ЫН ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС

## ЦАГ АГААР

### УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 22	🌧️ 8

### ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 32	🌧️ 23

## ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.850.0	2.853.0
EUR 🇪🇺	3.50.0	3.360.0
CNY 🇨🇳	440.0	441.0
RUB 🇷🇺	38.20	39.40
JPY 🇯🇵	25.58	26.02
KRW 🇰🇷	2.42	2.51

## ЗУРХАЙ

2021.08.13 БААСАН ГАРАГ  
/БИЛГИЙН ТООЛЛЫН 5/

**НАМРЫН ТЭРГҮҮН УЛААН  
БИЧ САРЫН НАЙМАН ЦАГААН  
ХАРАГЧИН МОГОЙ ӨДӨР**

Үс засуулбал:

**Эд мал арвижна**

Наран ургах, шингэх:

05:45-20:10

Барилдлага:

Үл тохирох

Шүтэн барилдлага:

Өтлөн үхэхүй

Суудал:

Шороо

Энэ өдөр үхэр, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой.

Эл өдөр санасан хэрэг түргэн бүтнэ. Бүтээл үйлдэх, тус чухалчлах, хэл ам дарах, башир, хатуу, түргэн үйлнээ сайн, гэрийн үйл, бие угаах, хувцас өмсөхөд сайн. Баруун нүд татвал зочин ирэх, зүүн нь татвал хувцас олох, баруун чих цангинавал баярлах, зүүн нь бол муу. Нохой уливал амгалан сайн болох, тагнай загатнавал дээрэм ирэх, бие татвал аюул болно.

**ДОРНЫН ЗУРХАЙ:** Үс засуулбал эд мал арвижна

## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 178.436	ЭДГЭРСЭН 161.878	НАС БАРСАН 869
+1443	+2000	+6

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 4309	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ 190	ЭДГЭРСЭН 4037
+78	+14	+14

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

<b>Тохиолдол</b> Нийт: 205,521,376
<b>Эдгэрсэн</b> Нийт: 184,481,876
<b>Нас барсан</b> Нийт: 4,337,772

**КОВИД-19**  
Өвдөөд эдгэрсэн таны, миний хайртай хүмүүс нийгмийн гадгуурхалд өртөх ёслүй!

КОВИД-19-өөр өвдсөн хүмүүс нийгмийн гадгуурхалд болж сэтгэлийн түгшүүр, бүхимдал & цочрол д ордог

Өвдөөд эдгэрсэн хүмүүсийг ялгаруулан гадгуурхах нь ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСЛЭЛГҮЙ & ХҮНЛЭГ БҮС зүйл юм.

КОВИД-19-өөр өвдөөд эдгэрсэн хүнтэй харилцах нь АЮУЛГҮЙ бөгөөд буддыг ХАЛДВАРЛУУЛАХҮЙ.

Эдгэрсэн хүн вируссын калдварыг ДАМЖУУЛДАГҮЙ болохыг шинжлэх ухаанаар баталсан.

ЦАХИМ ШУУДАНД

"ТҮМЭН ОЛОНДОО ЗОРИУЛСАН МИНИЙ ДУУНУУД" УНШИГЧДЫН ГАРТ ОЧЛОО



МУГЖ Н.Чулуунхүүгийн гэсэн дурсгалд зориулан хэвлэсэн "Түмэн олондоо зориулсан миний дуунууд" зохиолын дууны цуврал 4 боть номын нээлтийн арга хэмжээ өчигдөр "Интерном" номын дэлгүүрт болоо.

Тус бүтээлийг түүнийг тэнгэрийн орноо тухалсан 47 дахь хонот нь амжиж хань М.Мөнхбуянт, охин Б.Мөнхжаргал нар нь сэтгэлийн их өргөл болгож баринтаглажээ.

Номын нээлтэд бага, дунд ангид хамт сурч байсан ангийнхан нь болоод хугацаат цэргийн албыг хамтдаа хаасан нөхөд нь, мөн хамт уран бүтээл туурвисан зохиолчид, ах дүү, найз нөхөд, төрөл төрөгсөд гээд зааланд багтахаргүй олон хүн хуран цугларсан нь Н.Чулуунхүү гэдэг хүн ямар их нэр хүндтэй, бас ямар ихээр үгүйлэгдэж буйн баталгаа болж байлаа. Дуу хуур цалгиах явсан хүний хойчийн буян нь мэдээж дуутай хуртай байж, өөрийнх нь зохиосон олон сайхан бүтээлээс эгшиглэсний зэрэгцээ дурсамж цалгиасан өдөр болж өнгөрлөө.

Тэр бүхнээс нэгийг нь онцлоход, УИХ-ын гишүүн, асан Ш.Батбаяр тэд тухайн үеийн Ардын Армийн 065 дугаар ангийн нэг оны цэргүүд аж.

Тэр бээр амьдралынхаа хугацаанд эх орон, уул ус, цэрэг, хил, цагдаа, аав ээж, ахан дүүс, мэргэжил, эзэнтэй дуу, хайр сэтгэл, хань ижил, хутагт хувилгаад, шүтээн, анд нөхөд, ард түмэн, морь мал зэрэг бүхий л төрлийг хамруулсан 800 гаруй дуу зохиосон уйгагүй хөдөлмөрч хөгжмийн зохиолч байсныг нь урлаг соёлын алдартнууд хүлээн зөвшөөрч, судар номын хуудаснаа зориуд тэмдэглэсэн байна. Тухайлбал, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн хошой шагналт, Ардын жүжигчин, доктор, профессор Н.Жанцанноров "...Н.Чулуунхүүгийн дууг дуурийн аварга дуучдаас эхлээд хөдөө нутгийн малчин, хүүхэд хөгшид хүртэл дуулна. Түүний дууны сэдэв оройгүй тэнгэрээс орчлонт ертөнц, эх орноос ээжий аав, элбэрэлт ханиас энхрий үрс гээд монгол хүний ахуй амьдрал, хүсэл зориг, итгэл бишрэл, хайр энэрэл, гуниг баясал бүхнийг хамарна. Тэр дуу нь сайхан, энэ дуу нь тааруухан гэж эрэмбэ тогтоохын аргагүй..." гэж чигч шударгаар үнэлсэн нь чухам үнэн билээ.

Шинээр хэвлэгдсэн 4 ботид лавтайяа 500 гаруй яруу найрагчийн шүлгээр бүтсэн дуу орсны нэлээд нь манай цэргийнхэн, тэр

дундаа өндөр алба хашиж явсан генерал, хурандаа нар байгаа нь эрхгүй анхаарал татна. Тухайлбал, БХЯ-ны сайд агсан Ш.Жадамба генерал, ЗХЖШ-ын дарга асан, дэслэгч генерал Ц.Дашзэвэг, Ар талын газрын дарга асан, хошууч генерал Д.Магсаржав, АДХЦ-ийн командлагч асан, хошууч генерал Ч.Улаанхүү, Хилийн цэргийн генерал Ш.Арай, хурандаа, яруу найрагч агсан Л.Төмөрбат, бэлтгэлд байгаа хурандаа, яруу найрагч Ш.Эрдэнэбаяр, эдүгээ ЗХЖШ-ын Хэвлэлийн төлөөлөгч, яруу найрагч, хурандаа Б.Отгонбаяр нарын нэр дурайж байгаа нь Зэвсэгт хүчний алба хаагчдын бахархал байхаас аргагүй.

Н.Чулуунхүү агсны охин, хөгжмийн зохиолч Б.Мөнхжаргал "Бид аавынхаа уран бүтээлийг цаашид ч судлан, дэлгэрүүлэн түгээнэ. Тийм учраас энэ цаг мөчөөс эхлэн "Чулуунхүү сан"-г албан ёсоор байгуулснаа сонордуулж байна" гэсэн юм. Сайн хүний буян цаг ямагт дэлгэрч байдаг учраас, гавьяатын маань ахуй бие нь тэнгэрийн орноо одсон ч, уран бүтээлээрээ ард түмэнтэйгээ мөнхөд хамт оршихын тавилантай буюу.

Г.БААТАРНУМ



НИЙТИЙН ТЭЭВРИЙН 24 ЧИГЛЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАВ



Өчигдөр өдрийн 06:00 цагаас энэ сарын 16-ны 06:00 цаг хүртэл Зүүн дөрвөн замын уулзварын хөдөлгөөнийг хязгаарлан, засвар шинэчлэлтийн ажил хийх болсонтой холбогдуулан Нийтийн тээврийн 24 чиглэлд өөрчлөлт орж, троллейбусны гурван чиглэл түр зогсож байна.

Өөрчлөлт орж буй 24 чиглэл:

- Ч:1"5шар-Офицеруудын ордон" /цахилгаан/
- Ч:2 "Шархад - МУБИС - 3,4 -р хороолол"
- Ч:3 "Зүүн салаа - Халдвартын эмнэлэг"
- Ч:10"Ганц худаг - Сансар - Баянмонгол хороолол -Мишээл экспо /Нийслэлийн нэгдсэн үйлчилгээний төв"
- Ч:17а "Баруун 4 зам - Их тойруу - Зүүн 4 зам - Нарны зам" /их тойрог/
- Ч:17б "Баруун 4 зам - Нарны зам - Зүүн 4 зам - Их

- тойруу" /их тойрог/
- Ч:19а "Цагаан давааны задгай- Офицеруудын ордон - Сансар" /зүүн тойрог/ Ч19б "Цагаан даваа задгай - Сансар - Офицеруудын ордон" /зүүн тойрог/
- Ч:26 "Тоосгоны үйлдвэр - Ботаник - Жанжин клуб"
- Ч:29 "Сэлбэ амралт - МУБИС - Вокзал" /экобус, цахилгаан, том овор/
- Ч:31 "Улиастай - Баянбүрд - Зам гүүрийн автобааз"
- Ч:32 "Улиастай - Баянмонгол хороолол - ТЭЦ 3"
- Ч:33 "Шархад - 7 буудал - Зунжин худалдааны төв"
- Ч:37 "Улаанхуаран - 4 хороолол"
- Ч:40 "Мах импекс - Тэнгискинотеатр - Улаанхуаран"
- Ч:41 "Баруун салаа - Их тойруу - Халдвартын эмнэлэг"

- Ч:49 "1-р хороолол - Модны 2 - МУИС - Дунжингарав худалдааны төв"
- Ч:50 "Улаанхуаран - Мишээл экспо"
- Ч:51 "3,4 хороолол - МУИС - Дунжингарав худалдааны төв"
- Ч:59"ХМК-Офицеруудын ордон" /цахилгаан , их багтаамж/
- Ч:61 Офицеруудын ордон-МУБИС-120 мянгат-Алтай хотхон-Мишээл экспо
- Ч:64 "Цагаан давааны задгай - Офицеруудын ордон-Халдвартын эмнэлэг"
- Ч:65 "Зайсан-Офицеруудын ордон" ХО:2 "Шарга морьт - Дунжингарав худалдааны төв"
- Түр зогсолт хийх 3 чиглэл
- Т:2 "5 шар - Ботаник"
- Т:4 "Ботаник - Вокзал"
- Т:5 "3. 4 хороолол - Офицеруудын ордон"

**Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төв**

**МОГОЙД ХАТГУУЛАХААС СЭРГИЙЛЬЕ!!!**

**МОГОЙД ХАТГУУЛСАН ҮЕД АВАХ АНХНЫ ТУСЛАМЖ**

1. Арзгар бус амсартай шил, саваар бумбадах
2. Өөрөө эсвэл бусдаар хорыг соруулж, нулиман хаяж амаа зайлах
3. Хөлд хатгасан бол хөлтэй нь, гарт хатгуулсан бол тохойтой нь нугалж давуу, самбаа тавьж боох
4. Гар хөлдөө хатгуулсан бол удаан хугацаагаар хүйтэн усанд дүрэх
5. Могойд хатгуулсан хүнд шингэн ихээр өгөх
6. Цаг алдвал амь насанд аюул учрахыг **АНХААР!**

**ХОРТОЙ МОГОЙД ХАТГУУЛСАН ҮЕД:**

- Богино хугацаанд хатгасан газар нь хавдана
- Маш жижигхэн шарх үүснэ
- Ганц дусал цус шүүрнэ
- Аль болох хөдөлгөөнгүй байх
- Ичээнээс гарах үеийн могойд хатгуулвал хордох нь илүүтэй.